

Фройдын онол дахь нийгэм, соёлын мөн чанарыг тайлбарлах нь

Social and cultural nature on Freud's theory

Доржпүрэвийн Чулуунгэрэл¹

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн

Философийн хүрээлэн

Бодлого судлал, улс төрийн эдийн

засгийн салбар

chuluungerelD@mas.ac.mn

Болд-Эрдэнийн Мягмарцэрэн^{1, *}

Магистр

Шинжлэх Ухааны Академийн

Философийн хүрээлэн

Улс төр, эрх зүйн салбар

myagmartserenb@mas.ac.mn

Chuluungerel Dorjpurev¹

Doctor (Ph.D)

Department of Policy Studies & Political

Economy, Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

chuluungerelD@mas.ac.mn

Myagmartseren Bold-Erdene^{*}

Master of Arts

Department of Political Science & Legal

Studies, Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

myagmartserenb@mas.ac.mn

Хураангуй:

Орчин үеийн Өрнийн философийн нөлөө бүхий нэг гол чиглэл нь Фройдийн онол юм. Фройдийн психоанализийн онолд хүн, түүний ертөнцөд эзлэх байр суурийн тухай асуудал голлодог.

Тиймээс ч сүүлийн жилүүдэд З.Фройд, түүнийг залгамжлагчдын сэтгэл зүйн шинжилгээний сургаалыг олон талаас нь судлах болжээ. Түүний үзэл нь үнэхээр олон талтай юм.

Өмнөх үеийн сэтгэгчдээс З.Фройдийн ялгагдах онцлог нь хүний хөгжил болон оршихуйд түүний дотоод хүчин зүйлийн үүргийг гол болгон авч үзсэн явдал юм. Хүний дотоод ертөнц сэтгэгч нь хүнийг тодорхойлогч гол зүйл болдог тул объект нь гадаад ертөнц бус, харин хүний дотоод ертөнц, сэтгэцийн үйл явдлууд болдог.

Түлхүүр үгс: психоаналитик философи, нийгэм соёл, хүний хөгжил, ёс суртахуун, улс төрийн хошуучлагч.

Abstract:

One of the most influential branches of modern Western philosophy is Freud's theory. Freud's psychoanalysis focuses on the question of human and his place in the world.

Therefore, in recent years Z. Freud and his successors have been studying the psychoanalytical doctrines from many angles.

His views are truly multisided. The distinguishing feature of Z. Freud from the thinkers of previous generation is that he mainly considered the role of internal factors in human development and existence. The inner world of a person is the main thing that defines a person, so the object is not the external world, but the inner world and mental events of a person.

Keywords: psychoanalytic philosophy, social and culture, human development, moral, political leader.

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

* Холбоо барих зохиогч.

I. Оршил

Фройдийн онолын түүх болон үндсэн ойлголт, сургаалийн тухайд: Ихэнх амьдралаа Вена хотод өнгөрөөсөн Австрийн еврей доктор Зигмунд Фройд 1856-1939 олон талаараа соён гэгээрүүлэлтийн үр хүүхэд нь байлаа. Философичид хүний уг чанар нь жинхэнэдээ сайн, хэрэв хүмүүс оюун ухаанаа удирдлага болгох аваас муу зүйл багасна гэж үздэг байсан бол Фройд хүний уг чанарын тухай үзлээ шинжлэх ухааны болон өдөр тутмын ойлголтуудаар илэрхийлсэн. Тэр муу зүйл нь орчны нөлөө байхаасаа илүү ихээр хүний уг чанарт суурилсан байдаг гэжээ. Түүний үзэл санааг (1895-1905, 1905-1920, 1920-1939) гэж ангилж болно. Эхэн үеийн гол амжилт нь үл ухамсарлагдахуйн психик аппаратын тухай өгүүлсэн сургаал болно. Тэрээр хүний сэтгэцийн ертөнцийг – би - (эго), тэр - (либидо), дээд би -(super эго) гэж хувааж үзсэн. Би нь либидо ба гадаад ертөнц хоёрыг холбогч, дээд би нь нийгэм соёлын шинж чанартай хориг саад болно. Эдгээр гурван хэсэг нь өөр хоорондын байнгын зөрчил тэмцэлтэй байдаг. “Би” нь либидог захирах гэж оролддог, гэвч энэ нь бүтэхгүй бол зөвхөн үзэгдэх байдлаараа л “би” нь либидог захирч буй дүр эсгэнэ. “Би” нь их л хавчигдмал байдалд оршино. Нэг талаас гадаад ертөнц, нөгөө талаас либидо, гурав дахь талаасаа “дээд би” гэх чанд хатуу зарчмууд түүнийг байнгын зөрчил тэмцэлд байлгана. Энэ санаа бол хүн гэгч амьтан нь дотоодын зөрчилгүй, нэгдмэл байдаг гэсэн үзлийн эсрэг гаргасан сургаал юм. Манайд Фройдийн онолын судалгааг философийн ухааны доктор Б.Батчулуун судалсан байдаг.

II. Судалгааны арга зүй

Өгүүлэлд түүхэн ба логик шинжилгээ, харьцуулсан арга зүй, баримтын шинжилгээ, ажиглалт, системийн арга зүй, норматив-үнэлэмжийн арга, танин мэдэхүйн аргыг ашигласан. Ингэхдээ сүүлийн жилүүдэд хувь хүн, ард түмний санаа бодол, нийгмийн сэтгэл зүйг ихээхэн анхаарж зарим судалгаа шинжилгээнд энэ талын онолыг баримталж улс төрийн өнөөгийн байдлыг ч тайлбарлаж авч үзэх болсон.

Нийгмийн психологи гэдэг бол хувь хүний бодол өөр нэг хувь хүний бодолтой таарахгүй гэх мэтээр явж явсаар эцэстээ олонхийн санаа бодолд тохирсон хандлага нийгэмд тогтохыг хэлнэ. Нийгэм дэх оюун санааны тогтоцод нарийн ээдрээтэй зүйл их байдаг боловч хувь хүний психологитой харьцуулан авч үзэхэд зохих хэмжээгээр ойлгогддог гэсэн санааг салбартаа хэлэлцүүлж сэдвээ нарийвчлан томьёолсон болохыг энд дурдах нь зүйтэй.

III. Судалгааны үр дүн

Бид энэхүү өгүүллийн хүрээндээ Фройдийн онол дахь нийгэм, соёлын мөн чанарыг тайлбарлахыг хичээв. Тодруулбал, психоанализийн философийн үүссэн гол нөхцөл нь позитивизмын хэтэрхий туйлширсн байдал болон иррационализм хоёрыг даван туулах гэсэн эрмэлзлээс үүсэлтэй. Тиймээс энэ философи нь хүний ахуйн үндсийг эрж хайх, психикийн бүрдүүлэгч элементийг олох, тухайн хүний амьдрал үйл ажиллагаагаа явуулах зарчим, хувь

хүний төлөв байдлын сэдэл, шалтгаан зэргийг судалсан байна. Түүний судалгааны гол объект нь зөвхөн дотоод ертөнц төдийгүй харин тухайн хүний ахуй бүрэлдэн бий болоход нөлөөлдөг хамгийн гол үзэгдэл, үйл явц явагддаг психик ертөнц байв. Психикийн ертөнц өөрийн гэсэн мөн чанар, зүй тогтолтой өвөрмөц бодит байдал болно. Тэгвэл энэхүү өвөрмөц бодит байдлыг судалж, хүний психикийн зүй тогтлыг илрүүлж, хүний ахуйн гүнд болж буй дотоодын зөрчил зовлонг судлах нь психоанализ философийн гол зүйл юм. Хүний психик ертөнцөд өөрийн гэсэн өвөрмөц амьдралтай ерөөсөө судлагдаагүй, тэгсэн мөртлөө хүний зан төлөв байдалд маш их нөлөөлдөг, үл ухамсарлагдах оюун санааны давхарга байна гэж үзсэн. Хэрэв өнгөрсөн үеийн сэтгэгчид үл ухамсарлагдахуйн статусыг хамгийн сайндаа л гэхэд ухамсар ба үл ухамсарлагдахуйн харьцаагаар хязгаарлаж байсан бол психоанализ нь энэхүү үл ухамсарлагдахуйн агуулгыг судалдаг онцлогтой болно.

Бодит байдалтай зохицох зарчим гэдэг нь хүний сэтгэцийн үйл явцыг хүрээлэн буй орчинтой зохицуулан зааварлахаас гадна шууд дур ханах боломж байхгүйтэй холбогдон үүсэх хямралаас зугтаах чиглэл болдог. Энэхүү хамгаалагч механизм нь гүн гүнзгий зөрчлийг тэр болгон шийдээд байж чаддаггүй, хамгийн сайндаа л гэхэд нийгмийн хэм хэмжээнд тохирохгүй либидог үл ухамсарлахуй руу хөөн зайлулдаг. Шахан хавчигдсан либидо нь дурын агшинд таатай нөхцөл байдал бүрэлдэн бий болонгуут илрэн гарч, дараагийн зовлонгийн шалтгаан болно. Дотоодын зөрчлийг тайлах гол арга нь либидогоо ухамсартайгаар эзэмдэх эсвэл шууд хангах, эсвэл сублимаци хийх явдал юм. Зөрчлийн уг үндэс, шалтгаан болоод байгаа үл ухамсарлагдахуйг ухамсарт оруулж ирэн ойлгомжтой болгох ёстой. Ингэхдээ хэрэглэх арга нь зүүд нойр, чөлөөтэй ассиоцаци, алдаатай үйлдлүүд тул Фройдийн хувьд зүүд нойр гэдгийг бодит байдал биелэгдэхгүй хүслийн бодит илэрхийлэл гэж үзсэн байна. Тиймээс зүүдийг үл ухамсарлагдахуйн нууцыг тайлах түлхүүр гэдэг. Үл ухамсарлагдахуй гэдэг нь мартагдсан зүйл юм. Хүмүүс заримдаа зүүдээ ойлгодоггүй. Учир нь үл ухамсарлагдахуй шинж чанартай байдагт оршино. Зүүд нойрондоо хүүхэд насаа зүүдэлнэ гэдэг нь бага насныхаа хүслийг санана, томрох тусмаа бага насаа улам их санадаг. Алдаатай үйлдлүүд гэдгээ ухамсартай мөртлөө санамсаргүй зарим нэг зүйлийг андуурах явдал гэж үзсэн. Гэхдээ энэ нь санамсаргүй зарим андуурал биш. Жишээ нь, нэр мартаж, төөрөгдөл гэх мэт. Тиймээс алдаатай үйлдлийг хангалттай хэмжээнд дарагдан, ухамсраас шахагдсан ч өөрийгөө илрүүлэх чадвараа бүрэн алдаагүй сэтгэцийн хүчин зүйлстэй холбож тайлбарладаг.

Психоанализ нь үл ухамсарлагдахуйг танин мэдэхдээ одоог өнгөрсөн рүү, хүүхэд нас руу нь шилжүүлж байж, танин мэднэ. Учир нь үл ухамсарлагдахуйн үүг үндэс нь эцэг эх ба үр хүүхдийн хоорондын бэлгийн харьцаатай холбоотой. Психоанализийг дараах утгуудаар ойлгож болно. Үүнд: (i) психоанализ нь хүний сэтгэцийг задлан шинжлэх арга, хэлбэр; (ii) психоанализийн онол нь өөрөө практик болон хувирсан; (iii) психоанализ шиг хүмүүсийн хоорондын харилцаанд, соёл урлаг, утга зохиолд гээд нөлөө үзүүлсэн салбар байхгүй.

Хүний балчир хүүхэд байхдаа мэдэрсэн бүхий л оюун санааны туршлага, тухайн хүний хойшдын амьдралыг тодорхойлдог. Мөн өөр нэг хүчин зүйл нь бэлгийн хүмүүжил бөгөөд энэ нь психикийн хүмүүжил юм. Эндээс дүгнэхэд үл

ухамсарлагдахуй нь хүний бага насандаа туулж өнгөрүүлсэн амьдралыг сануулагч хөшөө болно. Хүний оюун санааны амьдралын хүрээ хэзээ ч ухамсраар хязгаарлагдахгүй. Үл ухамсарлагдахуй руу ороод тунасан сэтгэлийн шаналал ухамсар луу орж ирж болно. Гэвч ингэж орж ирэхгүй байгаагийн шалтгаан нь эсэргүүцэл юм. Хүний амьдралыг хүсдэг хүсэл эрмэлзэл нь бэлгийн дур хүслээр илэрдэг. Бүх юмны тэр дундаа хүн, хүмүүсийн хоорондын харилцаа, нийгмийн харилцааг ч тэр сексээр дамжуулан тайларлах гэсэн. Фройдизм нь хэлбэр-үзэгдлийн хувьд бэлгийн харилцаа, дур тачаалын тухай яриад байгаа боловч агуулга-мөн чанараараа хүн, түүний амьдралын учир шалтгааны тухай өгүүлдэг.

Хүний үйл хөдлөл, төрх байдлыг тайлбарлахад бидний ухамсар гэж яриад сурчихсан тэр зүйл бус, харин ухамсарлагдаагүй психик үзэл буюу либидо гол байр эзэлнэ. Хүн ухамсарт захирагдсан үедээ хэдийгээр нууж чаддаг боловч зарим эгзэгтэй үед өөрийн эрхгүй илрэн гардаг хүний “ёозгүй” шинжүүд үүнтэй холбоотой ажгуу. Сайтар ажиглан шинжилбээс хүн, тэр ч байтугай хамт олон, бүхэл бүтэн улс үндэстний байдлыг тайлбарлах түлхүүр болдог ухамсаргүй психикийг олон зүйл дээрээс харж болох боловч эр эмийн биологийн харилцаанд хамгийн тод илэрдэг. Иймэрхүү хүндрэлтэй байдал нь Фройдист онолыг манай Монголчууд шиг “ичимхий психологитой” ард түмэнд үнэмшилгүй мэт санагдахуйц болгож, судлахад төвөг учруулж болох талтай хэмээн философийн ухааны доктор Б.Батчулуун үзсэн байдаг. Бидний хувьд Фройдийн ярьж, сургаж буй зүйлс хэт этгээд, ичгүүргүй мэт санагдаж болох юм. Гэвч түүний өөрийнх нь хэлснээр шинжлэх ухаан танин мэдэхүй нь хэн нэгэнд таалагдах, эс таалагдах, тайвшруулах, эндүүрүүлэх тухайд огтхон ч санаа тавьдаггүй, харин үнэнийг л хэлэхэд бүх анхаарлаа чиглүүлдэг.

Ихэнх барууны судлаачид З.Фройддын психоанализ нь клиник судалгааны баримтууд дээр үндэслэсэн гэж үздэг. Философи үзэл санааны тухайд гэвэл Фройд өөрөө философичдын хийсвэр сэтгэлгээнд ихэд болгоомжтой ханддаг, тэгээд ч өөрөө ямар нэг философийн үзэл санаа байхгүй гэдгээ мэдэгдэж байсан. Тэр ч бүү хэл зарим нэг судлаачид Психоанализын сургаал нь Шопенгауэр болон Ницше нарын үзэл сургаалтай зарим нэг төстэй ижил шинж байгааг тодорхойлоход энэ бол эндүүрэл гээд Фройд өөрийн биеэр эдгээр философичдын үзэл сургаал нь Психоанализын үндсэн концепцүүд боловсрогдож байх үед дээр дурьдсан философичдын зохиол бүтээлтэй танилцаагүй байсан гэж мэдэгдсэн байна. Ямар ч байсан Фройд өөрийнх нь сэтгэлгээнд зохих нөлөө үзүүлсэн Ницше, Шопенгауэр нарын философийн талаар тодорхой ойлголт төсөөлөлтэй байсан боловч яагаад ч юм бэ янз бүрийн шалтгааны улмаас энэ тухайгаа хүлээн зөвшөөрдөггүй байсан бөгөөд гэхдээ үүнийг психоанализ нь философитой ямар ч холбоо хамааралгүй шинжлэх ухаан мөн гэсэн утгаар ойлгож болохгүй. Тэр ч бүү хэл зарим нэг судлаач шинжээчид Декартын үзэл бодлын цогц нь Фройддын үндсэн ойлголтуудтай адил бөгөөд тиймээс Фройддын үндсэн ойлголтууд нь Декартын философиос үндэслэн гарсан гэдэг. Харин ялгагдах гол онцлог нь Декартын дуализмыг даван туулсанд оршино гэж үздэг. Гэхдээ асуудлын гол нь Фройддын философийн эх үндсийг Декартын философи ч юм уу өөр хэн нэгэн сэтгэгчийн философитой адилтгах гэсэндээ гол нь биш юм. Хамгийн гол нь энэхүү сургаал

маань хүн төрөлхтний философи сэтгэлгээний түүхэн хөгжлийн явцад гарч ирсэн, гарч ирэх ёстой байсан үзэл сургаал, философи мөн гэдгийг л хэлэх гэсэнд байгаа юм. Тэгээд ч философийн үзэл сургаал болон психоаналитик хоёрын хоорондын түүхэн холбоо, хамаарлын тухай асуудал нь бүхий л эргэлзээ, хоёрдмол байдлыг даван туулж нэгдмэл хариу өгөх хүртэл түвшинд судлагдаагүй гэж үзэж болно. Иймийн учир Фройдын психоанализ үүсэн бий болсны үндэс шалтгааныг нь зөвхөн л философи сэтгэлгээний нөлөө байсан гэж үзэх нь хэр зэрэг бодитой вэ? Тэгвэл энэ талаар Фройд өөрөө юу гэж хэлснийг авч үзэцгээе.

“Шахаа”-ны тухай сургаал маань зөвхөн миний санаа л байсан билээ. Тэгээд ч Шопенгауэрын “Мир как воля и представление” гэдэг зохиолдоо тэрээр ухамсаргүй байдлыг хэрхэн тайлбарласан байсныг надад үзүүлэх хүртэл би шахааны тухай сургаалаа зөвхөн минийх л гэж бодож байсан. “Бодит байдлын ямар нэг сэтгэл шаналгасан үзэгдэл, үйл явцыг эсэргүүцдэг эсэргүүцэл хүнд байдаг тухай санаа нь миний шахааны тухай онолтой төстэй боловч би яг миний уншсан зүйл тун нэг их бишийн ачаар л би өөрийн онол, нээлтийг хийжээ” гэсэн байна. Мөн Фройд өөрийн урсгал зохиол бүтээлдээ бэлгийн амьдрал нь хүний төлөв байдал, үйл ажиллагаанд ямар их ач холбогдолтой болох талаар Шопенгауэрын гаргасан үзэл санааг ч иш татсан байна. Шопенгауэрын үзснээр үхлийн тухай асуудал нь ямар ч философийн хамгийн анхны анхаарах сэдвийн нэг байдаг гэж бичсэн байна. Ницшед хандах Фройдын хандлага ч түүний Шопенгауэрт ханддагтай төстэй. Гэхдээ 1908 онд Фройдын зохион байгуулсан цуврал лекцүүд дээр тавьсан илтгэлдээ тэрээр урьд өмнө нь Ницшегийн зохиол бүтээлийг уншиж байгаагүй, тиймээс ч энэ сургаал нь психоанализ үүсэн бий болоход нөлөөлөөгүй гэжээ.

Дээр дурьдсан бүхнээ нэгтгэн дүгнэх юм бол Шопенгауэрын философи нөлөөлсөн гэсэн үг үү, эсвэл Фройд өөрийн сургаалаа боловсруулчихаад хожим хойно нэмэлт өөрчлөлт оруулах үед л нөлөөлсөн юм болов уу гэдэг асуудал гарч ирнэ. Гэхдээ психоанализыг үүсэн бий болох үед Фройд Ницше болон Шопенгауэрын үзэл сургаалтай огт танилцаагүй байсан гэвэл үндэслэлгүй юм. Учир нь XIX зууны II-р хагас гэхэд энэхүү хоёр сэтгэгчийн философийг тухайн үеийн боловсролтой сэхээтэн хүмүүс, оюутнуд бүгд сонирхон судалдаг, уншдаг байсан тул энэ бүхнээс Фройд ангид байсан гэвэл худал болно. Тэгээд ч тэрээр 1900 онд Ницшедэй биечлэн танилцсан бөгөөд өөрийнх нь эх зохиолуудыг ч олж авсан.

Психоанализын философийн үүслийн тухай асуудал яригдахад Фройд бол зөвхөн л зоологи, анатоми, биологи гэх мэт байгаль шинжлэлийн ухаануудыг судалсан философийн талаар судлах цаг зав байгаагүй мэтээр зарим нэг судлаачид батлахыг оролддог. Гэтэл үнэн хэрэгтээ Фройд оюутан байхдаа тухайн үед ихэд алдартай байсан Brentano философичийн лекцүүдэд суудаг, өөрийнхөө найзыг философи сонирхон судалдаггүйнх нь төлөө зэмлэн буруушааж байжээ. Тэр ч бүү хэл Фройд, Brentano-той биечлэн танилцаж, чухамхүү Brentano л түүнийг Дж. Миллийн зохиолыг герман хэл рүү орчуулах орчуулагч болгох санал дэвшүүлсэн байна. Тэр үеийн Брюккегийн физиологийн институт болон Венийн их сургуульд суралцаж байх сүүлийн жилүүддээ тэрээр байгаль шинжлэлийг онцгой сонирхон судлах болсон ба энэ

үедээ ихэд түгээмэл дэлгэрсэн байсан өвчтнийг ховсдох, усан болон цахилгаан аргаар эмчлэх эмчилгээний аргуудыг сонирхон судалж, 1885 онд Парист алдарт сэтгэл зүйч Шаркогийн лекцийг сонсож, Венийн эмч Брейертэй хамтран “Истерийг задлан шинжлэхүй” гэдэг зохиолоо бичсэн бөгөөд энэхүү зохиол бол психоанализын анхна эх үндэс төдийгүй цэвэр байгаль шинжлэлийн шинж чанартай гэдгийг харуулсан юм хэмээн олонхи судлаачид санал нийлдэг. Гэхдээ психоанализын философийг зөвхөн л эмчилгээний арга зүйтэй холбон тайлбарлах нь тэр болгон үнэнд нийцэхгүй. Энэ талаар С.Цвейг “паскаль математикийг”, Ницше “эртний сонгодог хэл зүй”-г сонирхон судалдаг байсан шигээр Фройдын хувьд эмчилгээ, эмчийн практиктай холбогдоно. Хэдийгээр энэхүү эмчилгээний туршлагаас эхэлсэн эхлэл нь түүний бүтээлүүдэд ямар нэгэн өнгө аяс өгөх боловч түүний сургаалын бүхий л үнэ цэнэ, ач холбогдлыг бүрэн гүйцэд утгаар нь илэрхийлэн гаргаж чадахгүй.

Фройдийн онол ба ёс зүй. Хүний оршихуйн тухай асуудал нь сайн ба муу, хүний үйл ажиллагааны сэдэл, ёс суртахууны хязгаарлалт, дур зоргоороо байх, гэм буруу, сэтгэл зовних гэх мэт асуудлуудтай нягт холбоотой билээ. Фройд хэдийгээр ёс суртахууны талаар тодорхой ном зохиол бичээгүй ч түүний зохиол бүтээлүүдэд ёс суртахууны шинж чанартай үзэл бодлууд олонтоо тохиолддог. Тэрээр хүний дур хүсэл болон ухамсрын хоорондын харьцааг судалж байсны хувьд хүн ер нь байгалиасаа буюу эхээс төрсөн цагаасаа л сайн, эсвэл муу байдаг уу гэсэн асуудалтай үргэлж тулгарч ирсэн. Ер нь ч энэ асуудал нь философийн түүхэнд чухал байр суурь эзэлдэг ба энэ талаар ч философичид янз бүрийн үзэл сургаал, үндэслэлийг дэвшүүлж тавьдгийг бид мэдэх билээ.

Хүний ухамсаргүй дур хүслийг тайлбарлан, хүний зүүд нойрны утга учрыг илрүүлэн гаргаж байсны хувьд Фройд хүний мөн чанарт байгаа тэрхүү “муу дур хүслийг” хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрсэн. Түүнийхээр бол хүний зүүд нойронд нийгмийг эсэргүүцсэн ёс суртахууны эсрэг шинж чанартай дур хүслүүд илэрдэг ажээ. Учир нь унтаж байгаа үед хүний ухамсрын хяналт нь буурч, хүн өөрөө өөрийгөө хянах хяналт ч зогссон байдаг байна. Фройдийн үл ухамсарлахуй нь хүний оюун санааны ертөнцийн бүхий л муу муухай зүйл хадгалагдаж байдаг үүр уурхай ажээ. Тэгэхлээр энэхүү үл ухамсарлагдах дур хүсэл болон ёс суртахууны зарчмууд нь өөр хоорондоо зөрчилдөн, хувь хүнд сэтгэцийн хямрал болж үүсдэг. Түүний үзлээр бол түрэмгийлэл үйлдэх дур хүсэл бол хүнд хамгийн анхны инстинктив төрөлхийн байдлаар өгөгддөг. Нөгөө талаас ямар ч нийгэм, соёл иргэншил нь хүний түрэмгийлэх дур хүсэл илрэн гарах явдлыг хязгаарлаж байдаг ёс суртахууны зарчмууд, түүний хэм хэмжээн дээр үндэслэн оршдог. “Ойр дотны хүмүүстээ дайсагнах бидний дур хүслийг балчир байхаас нь эхлэн хориглож дарсан боловч бид одоо болтол өөрийн дайснаа хайрлах эсвэл зүүн хацраа алгадуулсны дараа баруун хацраа тавьж өгөх хэмжэнд хүрээгүй байна”

Дээр дурьдсанчлан хувь хүний үл ухамсарлагдах дур хүсэл болон нийгэм, соёл, ёс суртахууны зарчмууд, түүний хэм хэмжээний хоорондын зөрчлийн улмаас тухайн хүн сэтгэцийн хямралд орж болох бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэх, неврозоор өвчлөх гэх мэт хэлбэрээр илэрдэг. Бидний соёлтой гэж үздэг олон арван хүмүүс хэдийгээр аллага үйлдэж, цусан төрлийн холбоотой хүмүүстэйгээ бэлгийн харьцаанд орохоос татгалздаг ч гэсэн хэрвээ гэсгээл

шийтгэл үзэхгүй байх боломжтой бол өөрийнхөө муу зан авирыг гаргаж, бусдад жижиг хор хохирол учруулахаасаа огтхон ч татгалздаггүй. Хүн үнэндээ бусад хүмүүст өөдгүй, үл бүтэх амьтан болж харагдахгүйн тулд нийгэм, соёл, зан суртахууны хэм хэмжээ, зарчмуудыг хүлээн зөвшөөрдөг. Харин зүүд нойр, мөрөөдөлдөө өөрийгөө ёс сурахууны хэм хэмжээнүүдээс ангидаар төсөөлдөг. Тэрээр хүний үл ухамсарлагдах дур хүслийн тухай бодомжийг хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд үүсэн буй болсон ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудын үүсэлтэй холбон тайлбарлах хэрэгтэй гэж үзсэн.

Ёс суртахуун гэдэг бол гэм буруутайгаа ухаарсан, гэмшсэн сэтгэл дээр үндэслэн бий болсон байна. Гэхдээ ёс суртахууны үндсийг ганцхан “табу”¹ -тай холбон тайлбарлах нь утгагүй. Ийм тохиолдолд ёс суртахууны зарчим, хэм хэмжээнүүдийн нийгмийн бусад хэм хэмжээнээс ялгагдах онцлог гарч ирэхгүй юм. Мөн анхны хүй нэгдлийн нийгмийн үед эцгээ алсан явдлыг ёс суртахууны үүсэл гарлыг тайлбарлах арга зүйн үндэс болгож болохгүй. Тэгээд ч ёс суртахууны тайлбарлалдаа юм гэм буруу, гэмшил гэсэн ойлголтуудыг хэрэглэж байна. Эдгээр ойлголтууд өөрөө тийм ч ойлгомжтой, одорхой биш юм. Энэ эцгээ алсан явдлыг Эдипийн комплекс гэнэ. Энэ нь хүнд анхнаасаа төрөлхийн үл ухамсарлагдаагүй оюун санаа байдгийг баталдаг.

Фройдийн гол гавьяа нь зарим нэг философичид шиг хүний төлөв байдал, үйл ажиллагааны сэдэл, шалтгааныг ямар нэг хийсвэр байдлаар бус, харин хүний сэтгэцийн ертөнц дэх ёс суртахууны зарчмууд болон үл ухамсарлагдах дур хүсэл хоёрын зөрчлөөр ойлгоно. Өөрөөр хэлбэл, хүнийг өөрөөр нь дотоодоос нь гаднын ямар нэг хүчин зүйлээр бус тайлбарлахыг оролдсонд оршино. Түүний хувьд “категорический императив” гэдэг нь хүний үйл ажиллагааг тодорхойлох эсвэл урьдчилсан нөхцөл нь болох сэтгэцийн өвөрмөц механизм бөгөөд Фройдийн хувьд “Ёс суртахуун гэдэг бол өөрийн дур хүслийг хязгарлан барих явдал” юм. Түүний үзлээр чухамхүү хорио цээр, хязгаарлалт, хууль дүрэм бий болсноороо хүн амьтныг хүй нэгдлийн бүдүүлэг байдлаасаа улам бүр холдох боломжтойг харуулсан.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхийн явцад хүний байгалиас заяасан дур хүслээ хязгаарлан барьж байхыг шаарддаг хууль дүрэм, хорио цээр нь тухайн хүнийг өөрийнх нь сэтгэл санааны ертөнцийн салшгүй нэг хэсэг болгодог. Үүнийг “дээд би буюу *super ego*” гэж нэрлэх бөгөөд энэ нь бодит ертөнц дэх хүнийг амьдрал, үйл ажиллагаагаа зохих байдлаар засан залруулж, чиглүүлж байдаг ёс суртахууны хэм хэмжээнүүдийн цогцос юм. Үүний энгийн жишээ нь, дөнгөж төрсөн хүүхэд өөрийн амьдралын явцад нийгмээс өөрт нь тавигддаг бүхий л хэм хэмжээ, шаардлага, хууль дүрмийг өөртөө шингээн, өөрийн болгон нийгэмшсэн иргэн болдог. “Дээд би” нь нэг талаас хүнийг одоо байгаа байдлаас илүү гарч хөгжиж дэвшихийг уриалан дуудаж байдаг бол нөгөө талаас байгалиас өгөгдсөн өөрийн түрэмгийлэх шинж чанар бүхий бэлгийн дур хүслээ хязгаарлаж байхыг шаарддаг юм. Дээр дурьдсан сэтгэцийн

¹ Табу* хорио цээр, хязгаарлалт. Энэ нэр томъёо нь ариун, халдашгүй гэсэн утгатай полинез хэлний *tabu* гэсэн үгнээс гаралтай бөгөөд анхнаасаа шашны зан үйл, зан заншилд заориулан нөөцөлсөн, өдөр тутмын хэрэглээг хориглосон эд зүйлстэй холбоотой байжээ. Орчин үеийн хэрэглээний арга нь илүү өргөн цар хүрээтэй юм.

үзэгдлүүдийн өөр хоорондын зөрчлийн улмаас хүн гэдэг бол байнгын зөрчил, зөрчилдөөн дунд оршдог бөгөөд чухамхүү хүний ахуйг тогтвортой бус асуудалтай хэцүү болгож байгаа нь энэхүү үл ухамсарлагдах дур хүсэл болон дур хүслээ гаргачихвал ямар нэг шийтгэл хүлээх болов уу гэж айх зэрэг болно. Фройд орчин үеийн барууны нийгмийн ёс суртахуун нь цөөн тооны хэдхэн баячууд хүссэн цагтаа өөрийн дур хүслийг тэр доор нь ямар ч хэлбэрээр хангах явдлыг боломжтой болгосон гэж шүүмжилсэн байдаг. Мөн орчин үеийн барууны ертөнцөд мэдрэлийн өвчин ихэд дэлгэрч буйд санаа зовсон эмч хүний хувьд тэрээр энэхүү оршин тогтнож буй ёс суртахууны зарчмуудыг өөрчлөх хэрэгтэй гэж үзэж байсан ч яг тодорхой юу хийх вэ? гэдэг талаар дэвшүүлэн тавьсан зүйл байхгүй. Түүний ёс суртахууны талаар өгүүлсэн үзэл санаа, бодлогод айдсын тухай нилээн зүйл байдаг. Тэрээр энэхүү ойлголтыг нийгэм дэх хүмүүсийн харилцан үйл ажиллагаа ба соёл, зан суртахууны хэм хэмжээтэй холбон тайлбарлахыг оролдсон нь түүний үзлийн өвөрмөц онцлог болно. Энэ нь Эдипийн комплекс гэсэн ойлголтоор дамжин тайлбарлагдана.

Фройдийн онол дахь нийгэм, соёлын тухай бодомжууд. Ёс суртахууны талаарх психоанализын үзэл номлол нь нийгэм, соёлын тухай асуудлуудтай хамааралтай гэдэг нь ойлгомжтой юм. Мэдээж хэрэг, тэрээр ёс суртахууны тухай өгүүлэхдээ бодит байдлаас тасархай хийсвэр ёс суртахууны зарчмуудын тухай өгүүлээгүй бөгөөд харин эдгээр зарчмуудыг хүн төрөлхтний хөгжлийн түүхээс үндэслэн гаргаж, тухайн үеийнх нь нийгэм, соёлын хүчин зүйлтэй холбон тайлбарлахыг оролдсон нь түүний давуу тал болно. Хамгийн түрүүнд тэмдэглэн хэлэх ёстой зүйл бол Фройд хувь хүнийг нийгэмд нь эсрэгцүүлэн тавьсан явдал юм.

Хүн соёлыг эсэргүүцэн зогсдогийн шалтгаан нь соёлд биш, харин тухайн үед оршин тогтнож буй соёлын буруу хэлбэр, ёс суртахууны буруу хэм хэмжээнээс шалтгаалж байж болох юм биш үү? Фройдийн хэлснээр ирээдүйн хүмүүсийн соёлд хандах хандлага өөрчлөгдөх, түүнийг эерэгээр хүлээн авдаг болох бизээ. Түүний үзлээр бүх хүмүүс төрөлхийн залхуу, хязгаарлагддашгүй дур хүсэлтэй байдаг бөгөөд энэ нь хүний үйл ажиллагааг тодорхойлогч үндсэн хүчин зүйл болдог байна. Хэдийгээр хүнийг соёлын дагуу хүмүүжүүлдэг боловч дээр дурьдсан хоёр зан чанарын улмаас хүн төрөлхтний ихэнх хувь нь нийгмийг эсэргүүцэгч шинж чанараа хадгалсаар байдаг. Харин соёлыг зөвөөр, эрүүл агуулгаар хөгжүүлэхийн гол үндэс нь зөвхөн материаллаг баялгийг тэгшээр хуваарилах явдал юм гэх үзлийг хүлээн зөвшөөрөөгүй. Хэрэв хүн төрөлхтний соёл иргэншлийн анхны шатанд байгалийг захирах, материаллаг баялгийг бүтээх, түүнийгээ хуваарилах гэх мэт асуудал үнэтэй, хамгийн түрүүнд тавигддаг байсан бол өнөөдөр хүмүүсийн психикт анхаарах анхаарал улам бүр өсөн нэмэгдэж, хамгийн гол анхаарах цэг болж байна гэж үзсэн.

“Хүмүүс хэдийгээр байгалийг эзлэх, эрх мэдэлдээ оруулах талаар харьцангуй өндөр амжилт олсон ч хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулах тал дээр ийм өндөр амжилт олж чадаагүй л байна”.

Ер нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулж буй нийгмийн байгууллын цаана нь хэзээ ч дийлдэшгүй ямар их байгалийн хүч байна уу? энэ асуултад өгөх психоанализийн хариу ойлгомжтой. Тиймээс хүн төрөлхийн устгах, түрэмгийлэх дур хүсэл, энергийг өөртөө хадгална. Хувь хүнийг

нийгэм, соёлын амьдралд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаанд сургах явдал нь хүмүүжил, боловсролын гол зорилго юм. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл психоанализ ер нь эмчилгээний арга болохын хувьд ч тэр, хувь хүнийг нийгмийн бодит амьдралтай эвлэрүүлэх, зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

Психоаналитик философийн хувьд баримталдаг нэг гол зарчим нь соёлын хүчин зүйлүүдийг байгалийн хүчин зүйлсээр дамжуулан, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, үзэгдлийг хувь хүн, психологийн хүчин зүйлсээр дамжуулан тайлбарладаг явдал юм. Психоанализийн философийн нийгмийн асуудлын талаар өгүүлсэн үзэл бодлын онцлог нь юу вэ? энэ үүднээс авч үзвэл хувь хүний эрэлт хэрэгцээ болон нийгэм, соёлын шаардлага хоёрын хоорондын тэнцвэрт байдлыг хангаж чадах нийгмийн байгуулал байж уу? энэ тохиолдолд хамгийн түрүүнд тэмдэглэх ёстой нэг зүйл бол психоанализ философи нь нийгмийн тухай асуудлыг авч үзэхдээ хувь хүний сэтгэцийн ертөнцийг задлан шинжлэхдээ хэрэглэсэн тэр л аргаа, тэр л зарчмаа баримталсан явдал юм. Өөрөөр хэлбэл, хувь хүний оюун санааны ертөнцийг задлан шинжлэх гол зарчим нь хүнд төрөлхөөс заяагдсан агуу ир дур хүсэл, эрч хүч, энерги байсан бол нийгмийн үзэгдлүүдийг тайлбарлахдаа мөн л энэхүү зарчмаа баримталсан. Түүний үзлээр бол нийгмийн харилцаа холбоо нь бэлгийн харилцаа холбооноос ялгаатай байдаг ч гэсэн энэ нь психоанализ философийн нийгмийн тухай асуудлыг авч үзэхдээ бэлгийн дур хүслийн тухай харгалзан үзээгүй гэсэн үг биш юм.

Түүнчлэн тэрээр “массовая душа” / олон түмний санаа бодол / гэсэн ойлголт оруулж ирсэн бөгөөд хувь хүний оюун санааны ертөнцөд явагддаг бүхий л үйл явц энэхүү “олон нийтийн оюун санаа”-нд явагддаг гэсэн. Психоанализ философид хувь хүн ба нийгмийн судалгааны талаар ямар нэг ялгаа гаргадаггүй. Харин энэ хоёрыг адил хэмжээнд, адил арга зүйгээр авч үздэг. Фройдын өөрийнх нь хүлээн зөвшөөрснөөр “либидо” гэдэг ойлголтыг “массын психологийн” задлан шинжлэх үйл явцад хэрэглэхийг оролдсон. “Хүмүүсийн хоорондын нийгмийн харилцаанд хувь хүний либидогийн хөгжлийн явцад явагддаг тэр үйл явц тэр чигээрээ дахин давтагддаг”.

Тэрээр нийгмийн гишүүн бүрийн сайн сайхан, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн өгч чадахгүй байгаа шударга бус нийгэм, нийгмийн харилцааг шүүмжилж авч үзсэн. Тэгээд ч нийгэмд оршин тогтнож буй ёс суртахууны зарчмуудыг өөрчлөөгүй байж, зөвхөн материаллаг баялгийг зөв зүйтэй хуваарилснаар л тэгш эрх, шударга ёс бий болно гэх үзэл нь үндэслэлгүй гэсэн.

IV. Хэлэлцүүлэг

Орчин үеийн нийгэм нь хүнд маш өндөр ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудыг тулган тавьдаг бөгөөд үүний улмаас хүн өөрт нь байгалиас заяасан эрч хүчээ дарж, барьж байх шаардлагатай болж, ингэснээрээ нийгэм, соёл, ёс суртахууны хэм хэмжээ, шударга ёс, хууль дүрмийг байнгын даралт шахалт, зовлон мэтээр хүлээн авдаг. Ингэхлээр психоанализ нь нийгмийн асуудлуудыг хүний үл ухамсарлагдах дур хүэслтэй холбон тайлбарласан болохоор эцсийн үр дүн нь тийм ч бүрэн төгс биш юм.

Хувь хүн болон нийгмийн хоорондын зөрчлийг устгах талаар түүний дэвшүүлж тавьсан гол санаа нь орчин үеийн нийгэм дэх хүний дур хүслийг хязгаарлан барих явдлыг сулруулах нь чухал гэж үзсэн. Түүний үзлээр хүний зовлон үүсэх 3 нөхцөл байдаг. Үүнд: (i) хүний эрх мэдэлд хэзээ ч бүрэн гүйцэд орохгүй байх; (ii) хүний бие организм өвдөх, гэмтэх, үхэх; (iii) нийгмийн харилцааны төгс бус байдал орно.

Эхний 2 нөхцөл байдлын улмаас үүсэн бий болсон зовлонг арилгаж, устгаж, засан залруулж, зөөлрүүлж болдог бол өөрсдийнх нь үүсгэн бйу болгосон нийгэм, нийгмийн байгуулал нь өөрсдийг нь огтхон ч хамааралгүй шинж яанартай болсны улмаас хүмүүсийн сэтгэл санаанд үүсэх зовлон, шаналгаа түгшүүр их хэцүү байдаг. Ер нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулж буй нийгмийн байгууллын цаана нь хэзээ ч дийлдэшгүй ямар их байгалийн хүч байна уу? энэ асуултад өгөх психоанализийн хариу ойлгомжтой. Тиймээс хүн төрөлхийн устгах, түрэмгийлэх дур хүсэл, энергийг өөртөө хадгална. Тиймээс хүммүжил, боловсролын хамгийн гол зорилго нь хувь хүнийг нийгэм, соёлын амьдралд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаанд сургах явдал юм. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл психоанализ ер нь эмчилгээний арга болохын хувьд ч тэр, хувь хүнийг нийгмийн бодит амьдралтай эвлэрүүлэх, зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

Нэгэнт соёл гэдэг маань зөвхөн ганц хүний бүтээл биш, нийт олон түмний хүртээл юм болохоор Фройд хувь хүн болон нийт хүн төрөлхтний хөгжил хоёрыг зэрэгцүүлэн судлахыг хичээсэн. Тэрээр коллективный невроз / олон түмний бухимдал / гэдэг асуудлыг судлан, ер нь хүн төрөлхтний соёл иргэншлийн тодорхой үеүд тэр чигээрээ неврозоор өвчилсөн байж болох юм биш үү гэдэг асуудлын өмнө тулгарсан.

Олон түмний психологийн талаар Фройдийн хийсэн бас нэгэн гашуувтар боловч үнэн дүгнэлт бол олон түмэн төрөлхөөсөө ямар нэгэн удирдагчийг хүсэн хүлээж, эрэн хайж, уг чанараараа нэр хүндэд шүтэж байдгийг харуулсан. Олон түмэн удирдагчаа алдаад бүгд өөр өөрсдийгөө бодсон психологийн төлөв байдал болох паникаас ямагт зайлсхийж, зугтахыг оролдож байдаг. Энэ бол бүр сүргийн амьдралын үеэс үлдсэн инстинкт юм. Энэ инстинктээр олон түмний психологийн дээрх шинж тайлбарлагдана. Ард түмэн ямар нэг байдлаар өөрсдийнх нь анхаарлын төвд байгаа хүнийг итгэл найдварын нүдээр харж, түүнийхээ маш халгаатай дутагдлыг хүртэл хүлээн зөвшөөрөхөд бэлэн байдаг. Түүхэнд чанга гартайгаараа алдаршсан Чингэс, догшин Иван, Их Петр, Наполеон нар олон түмэнд хэдий чинэ хатуу хандана, тэд төдий чинээ дальдчин өөр рүү нь зүтгэдэг учир ийм ажээ. Олон түмнийг ийм фанатик улангассан байдалтай болгохыг Фройд захирах гипноз буюу “эцгийн гипноз” гэж нэрлэсэн. Гипнозийн энэ төлөв байдал нь олон хүнийг хамрах тусмаа улам бүр гүнзгий шингэдэг, үүнийг коммунист дарангуйллын доор байгсад илүү их мэднэ. Олон түмний психологид нэвтрэн орох “эцгийн гипнозийн” арга явуургүй болж, дэлхийн улс төрийн тавцнаас арчигдаж байгаа бөгөөд оронд нь Фройдийн тайвшруулах гипноз буюу “эхийн гипноз” гэж нэрлэсэн тэр арга зонхилох шинжтэй болж байна. Үүнийг ардчилал гэнэ.

Улс төрд олон түмний психологид таарч тохирох гэж оролдохгүй чигээрээ урагшилсан тэр хувь хүнийг нийгэм үл зөвшөөрнө. Тиймээс улс төрчид

өөрсдийн санааг ихээхэн бүдүүвчилж, олон түмэнд тохируулж байж бодлогоо амжилттай явуулдаг. Эс тэгвээс тэр хүн олон түмнээс хэт урагшаа гарчихаад түүндээ санаа зовон байн байн эргэн харсаар өмнөө байга ангальг харахгүй унах бөгөөд түүний оронд нь гарч ирсэн хүн олон түмэнтэй ойр байснаараа тэднээр гүүр хийж, ангал дээгүүр цаана нь гарах замаар улс төрийн амьдрал урагшилдаг дүр зураг харагддаг.

Фройдийн психоаналитийн онол нь өөрөө хувь хүн нийгэмд хэрхэн, ямар дүрээр оролцож, сонголт хийж нийгэм улс төр, соёлын амьдралд яаж нөлөөлөх тухай тайлбарлах суурь ойлголт гэж авч үзэх болох талтай. Үүнээс үзвэл нийгэмд хувь хүн газар зүйн онцлог, өсөж торнисон орчин, гэр бүлийн хүмүүжил, нийгмийн давхарга, эрүүл мэндийн байдал, нас хүйс жендэрийн ялгаа, боловсролын байдал, ажил мэргэжлийн онцлог, шашин шүтлэгээс хамаарж аливаа зүйлийг ойлгож хүлээн авж, хариу үйлдэл үзүүлж, ертөнцийг таниж мэддэг. Эдгээр хүчин зүйлс нь тухайн хүний сэтгэл зүйн байдалыг илэрхийлж, энэхүү сэтгэл зүйн онцлог байдлууд нь өөрөө нийгмийг бүрдүүлэх эх үүсвэр юм. Психоанализын үзлийн дагуу нийгэм, соёл гэдэг ойлголт нь хувь хүний үл ухамсарлагдах дур хүслээ шахаанд оруулсны үр дүнд оршин тогтнодог. Энэ нь юугаар илэрдэг вэ гэхээр хүнд төрөлхөөс заяагдсан дур хүсэл, эрч хүч, энерги гарган илэрхийлж болохгүйг хориглосон хорио цээр, хууль дүрмийн хэлбэрээр илрэн гардаг. Эрх мэдэл нь өөрөө хүний өөрийгөө батлахыг эрмэлзэх, ямар нэгэн зүйлд маняаар анхаарлаа төвлөрүүлэх сэдлийг өдөөж, хүний дээд би сэрсний улмаас аливаа улс төр, нийгэм соёлын үйл ажиллагаанд оролцуулдаг. Иймэрхүү Би нь өндөр эрх мэдэлтэй байхын зэрэгцээ ганцаараа байхыг эрмэлздэг бөгөөд гадаад ертөнцөөс тусгаарлагдах хандлагатай байдаг. Нөгөөтэйгүүр, ганцаардал нь мэдрэлийн эмгэгийг эрчимжүүлдэг бөгөөд тэдгээр нь эргээд гайхалтай шийдэл, дайралт, стандарт бус үйлдэл, эрх мэдэлд хүрэхэд либидо энергийг гадагшлуулахад хүргэдэг. Хүмүүсийн хоорондын нийгмийн харилцаанд хувь хүний либидогийн хөгжлийн явцад явагддаг тэр үйл явц тэр чигээрээ дахин давтагддаг. Эрх мэдлийн асуудал Фройдийн психоанализийн онолоор засаглалыг хэрэгжүүлж буй субъект нь нийгэмд эцгийн дүрээр илэрдэг ба хүмүүс эцгээ санагалзах инстинкттэй нь холбоотой. Энэ үзэгдэл нь удирдагчийн ухамсаргүй зан үйл, сэдлийг ухамсарлах гүн гүнзгий түвшний үйл явцын үр дүн гэж үзжээ.

Нийгэм, улс төр, соёлын амьдралд эрх мэдлээр дамжин хувь хүний манлайлах удирдах хошуучлах үзэгдэл төрмөл үү эсхүл түүхийн өөрчлөлтийн үйл явцад бий болдог уу? Үүнийг Фройдийн онол нь улс төрийн амьдралыг судлахад ч чухал ач холбогдолтой. Улс төрийг тайлбарлах психоаналитик хандлага нь улс төрийн харилцааны гүн гүнзгий, хувь хүний болон олон нийтийн мэдрэмжийг судлахад суурилдаг. Хүйс, масс, бэлгийн хэвшмэл ойлголт, хувь хүн, нийгмийн бэлгийн баримжаа зэрэг хүчин зүйлүүд нь улс төрийн үйл ажиллагааг гүнзгий өдөөдөг гэж үздэг. Үүнийг Фройдийн “Хошуучлагчийн сэтгэл зүйн онол”-оор тайлбарладаг. Тэрээр хэлэхдээ хүн эхээс төрөөд л манлайлах үйл явцтай тулгардаг. Томчуудын хажууд байснаараа хүүхдүүд тэднийг манлайлагч хэмээн харж дагаж дуурайдаг.

Психоаналитикийн байр сууринаас хувь хүний хөгжлийн 4 үе шатыг тодорхойлдог. Үүнд:

1. *Гэр бүлийн гарал.* Тухайн гэр бүл ямар ч түвшнийх байсан эцэг эхчүүдийн өмнө хүүхдээ хүмүүстэй харилцах тал дээр, нийгэмд амьдрах арга барилд сургах шаардлага гардаг. Хүүхдүүд бага насандаа өөр дээрээ илүү төвлөрөх ба эцэг эхчүүд хүүхдийнхээ хэрэгцээг хангаж өгөх хэрэгтэй. Нэг талаар эцэг эхчүүд өөрсдөөс нь хамааралтай тэр хүүхдийг удирдах гэж оролддог, нөгөө талаар хүүхэд ч эцэг эхээ удирдаж болдог.
2. *Хувь хүн болж төлөвших үйл явц.* Цаг хугацааны аясаар хүүхэд бие дааж, асран хамгаалагчдаасаа хараат бус байхыг хүсдэг. Тэгсэн ч эцэг эхчүүд түүний үйлдлийг зааж, шийдвэрүүдийг нь шүүж дүгнэлт хийсээр байдаг.
3. *Хараат ба хараат бус байдал.* Удирдагчдад үзүүлэх хариу үйлдэл нь хамааралтай эсвэл эстэг талын шинж чанартай байж болно. Хоёр дахь хувилбар нь дагагч нь удирдагчийн үйлдлийг үнэлж, удирдагчийн сонгосон үйлдлийн хувилбарууд тэдгээрийн үр дагаварын харьцуулсан шинжилгээ хийх замаар илэрхийлэгдэнэ.
4. *Хэлмэгдүүлэлт ба хувь хүний хар тал.* Хариуцлагын хүрээнд эцэг эхчүүд хүүхдийнхээ нийгмийн амьдралд оролцоход нь туслахаас гадна сайн муу, болно болохгүйн ялгааг тайлбарлана. Эцэг эхчүүд хүүхдээ болохгүй үйлдлийнхаа төлөө шийтгүүлдэг гэж ойлгуулдаг.

Хүний төлөв байдал, үйл ажиллагааны гол удирдагч, чиглүүлэгч нь оюун ухаан гэдэг нь тодорхой билээ. Гэтэл энэхүү ухамсрын цаана хүн өөрөө мэддэггүй асар их ухамсарлагдаагүй эрч хүч, энерги буцалж байдаг гэдгийг З.Фройд гарган тавьсан бөгөөд тэрээр сэтгэл мэдрэлийн эмч байсны хувьд эдгээр ухамсарлагдаагүй эрч хүч, энерги нь хувь хүний амьдралд ноцтой саад бэрхшээл учруулж болохыг ойлгон ухамсарлаж байсан. Иймээс энэхүү өвчлөлийг хэрхэн эмчлэх вэ?, өөрөөр хэлбэл, өвчтөний ухамсар болон үл ухамсарлагдах дур хүсэл, тачаал хоорондын зөрчлийг хэрхэн арилгаж эмчлэх вэ? гэдэг үүднээс психоанализ буюу сэтгэцийн задлан шижилгээ гэж нэрлэгдэх хүний оюун санааг тайлбарлах, оюун санааны эмгэгийг анагаах, эдгээх З.Фройдын арга үүссэн билээ. З.Фройд зөвхөн өвчтэй хүмүүсийн өвчний шалтгааныг тогтоон, тэднийг эмчлэх аргаар өөрийнхөө үйл ажиллагааг хязгаарлаагүй. Харин түүний байнгын бүтээлч хөдөлмөрийн үр дүнд зөвхөн өвчтэй хүний төдийгүй эрүүл хүний төлөв байдал, зан чанар, үйл ажиллагааг тайлбарлаж чадахуйц онолын систем боловсруулсан.

Барууны орнуудад З.Фройдын сургаал ихэд алдартай бөгөөд “Сэтгэл судлал бол З.Фройд” гэж үзэх нь ч бий. Мөн түүний үзэл сургаал сэтгэл судлалын бүхий л сурах бичгүүдэд орсон байхын зэрэгцээ улс төр, социологи, сурган хүмүүжүүлэх ухаан, антропологи, урлаг, утга зохиол гээд нийгмийн амьдралын бүхий л салбарын шинжлэх ухаанд ямар нэг байдлаар нөлөө үзүүлсэн байна. Өнөөдөр З.Фройдын үзэл санааг шүүмжлэлтэй авч үздэг, эсвэл сохроор бишрэн дагадаг, түүний үзэл сургаалаас үндэслэсэн маш олон үзэл санаа, чиг хандлага байгаа бөгөөд эдгээр үзэл бодлуудын чухам аль нь бодит байдалд илүү түшиглэсэн инжлэх ухааны үнэ цэнэтэй болохыг танин мэдэхийн тулд түүний өөрийнх нь оригиналь үзэл бодлын талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Психоанализ нь дараах утгуудаар ойлгогдоно. Үүнд:

1. Психоанализ нь хүнийг задлан шинжлэх арга хэлбэр мөн

2. Психоанализын онол нь өөрөө практик болж хувирсан, түүнээс өмнө хойно хэзээ ч ийм сургаал гарч ирээгүй. Фройд философичдын уламжлалаар хүний уг чанарын тухайд шинжлэх ухаанын анализ дээр тулгуурлан нийгмийг сайжруулах, хамгийн сайн зам нь оюун ухаан гэдэгт итгэж байлаа. Тиймээс хүний оюун ухаан 3 зүйлээс тогтоно. –эго-ухамсар, ид-төрөлхийн оюун санаа, супер эго-нийгмийн ухамсар гэсэн.

V. Дүгнэлт

Фройдын онолыг Францын философич Гельвецийн хэлснээр “Хүнийг хүн болгож байдаг зүйл бол ёс суртахуун мөн. Ёс суртахуун гэдгийг хамгийн энгийнээр тодорхойлох юм бол юуг зөв, юуг буруу, юуг сайн, юуг муу хэмээн үзэх хүмүүсийн итгэл үнэмшил юм”. Энэ итгэл үнэмшил ихэнх хүмүүст ижил байдаг. Үүнийг ёс суртахууны төлөв байдал, хэм хэмжээ гэнэ. Энэ хэм хэмжээний хүрэн дэх төлөв байдал, үйлдэлтэй хүнийг ёс суртахуунтай хүн гээд энэ хэм хэмжээг зөрчвөл ёс суртахуунгүй гэж нэрлэдэг. Ёс суртахуун нь нийгмийн хэм хэмжээ гэдэг утгаараа нийгэм дэх хүмүүсийн харилцааг зохицуулж байдаг. Ихэнх хүмүүс нийгэмд тогтсон сайн, зөв гэсэн ойлголтын дагуу үйл ажиллагаагаа явуулан, буруу муу гэсэн зүйлсийг хийж үйлдэхгүй байхыг боддог. Тэгэхээр энд юуг хийх ёстой, юуг хийх ёсгүйг хуулиар бус ёс суртахуунаар төдий л сайн ойлгож ухамсарладаггүй.

Ёс суртахууны нийгмийн агуулгыг авч үзвэл доорх дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд: (i) Ёс суртахуун бол хүний үзэгдэл юм; (ii) Ёс суртахуун нь харьцангуй хөдөлгөөнтэй өөрчлөгдөж байх зүйл юм; (iii) Ёс суртахууны хүмүүжил, төлөвшил нь хүмүүсийг бие биеэс нь ялгах нэг үзүүлэлт мөн гэдэгтэй санал нэг байна.

Өнөөдөр ёс зүйн шинжлэх ухааныг өргөн утгаар нь хөгжүүлж, аль ололт дэвшилттэй үзэл санааг ялган салгаж, өөрийн итгэл үнэмшил болгон авах нь зүйтэй. Тухайлбал, утилатиризмын ёс суртахууны ерөнхий зарчмыг өөртөө багтааж, сайн зүйл хийхийг зөвшөөрдөг байдал, тухайн нөхцөлд тохирсон сонголтдоо ямар хууль илүү үйлчлэхийг өөрөө тодорхойлон зүй зохистой хэрэглэхийн чухал болох, мөн өөрийн үйлдэл, бусад хүмүүсийн аз жаргалд хувь нэмэр оруулж байгаа эсэхийг шалгах чухал санаанууд байна. Үүнтэй адил өнөөгийн зах зээлийн үед харилцан ашигтай байх зарчим, хувь хүн болон нийгмийн ашиг сонирхол хоорондоо уялдаа холбоотой байх гэх мэт эгоизмын үзэл онол ч бидний амьдрал ахуйдаа хэрэглэхүйц ололттой зүйл мөн. Эртнээс эхлэн түүхийн янз бүрийн үеүдэд хүн, хүний мөн чанарын талаар олон янзын үзэл бодлууд ээлж дараалан гарч ирж байсан боловч З.Фройдын үзэл сургаал шиг өнөө болтол үнэ цэнэтэй байсан нь тийм олон биш. Үүний гол шалтгаан нь З.Фройдын сургаал нь хувь хүний дотоод ертөнцийн бүтцийн талаар хамгийн гол гол асуудлуудыг гарган тавьж, хувь хүний сэрэл, мэдрэмжийн талаар өгүүлж, мөн хүний дур хүсэл болон үүрэг харуцлага өөр хоорондоо хэрхэн зөрчилдөж байдаг тухай, хүн өөрийнхөө тухай болон хүрээлэн байгаа ертөнцийн тухай зөв, буруу төсөөллүд, ойлголтуудыг хэрхэн олж авдаг тухай, эдгээр нь хүний оюун ухаан, сэтгэл санаанд хэрхэн нөлөөлдөг гэх мэт олон асуудлыг дэвшүүлэн тавьсан төдийгүй энэхүү сөрөг нөлөөллийг хэрхэн арилгах вэ? хүн өөрийгөө хэрхэн танин мэдэх вэ?, эмчилгээгүй гэж үзэж байсан

сэтгэцийн эмгэг өвчнүүдийг хэрхэн анагаах вэ? зэргийг шинжлэх ухааны үндэстэй гарган тавьсанд оршино. З.Фройд хувь хүний оюун санааны бүтэц, зохион байгуулалт, бүтцийн элементүүдийн хоорондын харилцаа зэрэгт хүний хүүхэд нас, гэр бүлийн орчин тэргүүлэх үүрэг гүйцэтгэдгийг гарган тавьсан. Оюун ухаан нь ухамсар биш, энэ нь рациональ болон иррациональ зүйлийг тэмдэглэж байгаа ухагдахуун юм. Бид өмнө нь хүнийг тодорхойлдог зүйлийг рациональ гэдэг байсан бол З.Фройд иррациональ зүйл тодорхойлно гэсэн. Гэхдээ иррациональ зүйлийг ойлгож үнэнийг хэлсэн болохоос бус магтан дуулаагүй.

Ашигласан материал

1. Современная западная философия, словарь. (1990). М.,
2. Батчулуун Б. (1992). Эцэг эхийн гипноз. Уб., Үг сонин. №8.
3. Лейбин В.М. (1990). З.Фройд психоанализ и современная западная философия. М., стр. 15
4. Лейбин В.М. (1990). З.Фройд и современная западная философия. М., стр. 24
5. Фройд З. (1990). Остроумие и его отношения к бессознательному. М., стр. 137
6. Фройд З. (1995). Психоаналитические этюды. М., стр.19
7. Фройд З. (1927). Будущность одной иллюзии. стр. 9
8. Фройд З. (2018). Психология масса и анализ человеческого Я. стр. 90